



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/342

Сүхбаатар сум

Аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, Улсын нөөцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 16 дугаар зүйлийн 16.1.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3, 8.2.6, 26 дугаар зүйлийн 26.1.1, 35 дугаар зүйлийн 35.1, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 45 дугаар зүйлийн 45.3, Засгийн газрын 2018 оны 218 дугаар тогтоол, Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр журмын 2.3 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Мал аж ахуйн салбарын 2018-2019 оны өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг Засгийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу бүрдүүлэхийг аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Мөнхтөр/-д даалгасугай.


3. Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх зардал болох 10.000.000 /арван сая/ төгрөгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

4. Дээрх зардалыг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /М.Нарантуяа/-д зөвшөөрсүгэй.

4. Аймгийн аюулгүйн нөөцөд авах өвс, тэжээлийн чанар, стандарт, хадгалалт, хамгаалалт, зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/-д, ажлын тайланг аймгийн Засаг даргад 2018 оны 12 дугаар сарын 25-ны дотор гаргаж танилцуулахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Мөнхтөр/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ



Аймгийн Засаг даргын 2018 оны
09 дүгээр сарын 11-ны өдрийн /312/ тоот
захирамжийн хасвралт

№	Тэжээлийн төрөл	Худалдан авах нь /тн-оор/	Боодол буюу шуудай өвс, тэжээлийн жин /кг/	Тоо хэмжээ /боодлоор/	Нэг бүрийн үнэ төг	Бүгд үнэ төг
1	Өвс	50	2000		5000	10.000.000
Нийт зардал						10.000.000

Төсөв гаргасан:

Х.Цэнгэлсайхан

ХХААГ-ын МАА-н албаны дарга/

Хянасан:

О.Мөнхбаяр

/Аймгийн Санхүү, төрийн сангийн
мэргэжилтэн/